



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/247

Номгон

Г

Г

Төрийн архивын санг аймгийн түүхэнд
холбогдох гэрэл зургаар баяжуулах,
сэргээн хуулбарлах ажлыг зохион
байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны А/645 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаар 2023-2027 онд баримтлах бодлого чиглэл"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 90, аймгийн Засаг даргын 2026 оны А/25 дугаар захирамжаар баталсан Төсөл хөтөлбөр, бодлого стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай жагсаалтын 8 дахь заалтыг заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн 1941-2000 оны түүхэнд холбогдох онцлог гэрэл зургаар Төрийн архивын санг нөхөн баяжуулах, сэргээн хуулбарлах **"Алгасаж болохгүй түүх"** арга хэмжээг 6 дугаар сард зохион байгуулсугай.


2. **"Алгасаж болохгүй түүх"** гэрэл зургийн бүрдүүлэлтэд идэвхтэй оролцож ажиллахыг нийт сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт, Арга зүйгээр ханган, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн архивын хэлтэс (В.Эрдэнэчимэг)-т нарт тус тус үүрэг болгосугай.

3. Иргэдийн хувийн санд байгаа аймгийн түүхэн холбогдох гэрэл зургаар Төрийн архивын санг баяжуулах, сэргээн хуулбарлах, тайлбар тэмдэглэл авах, эх хувийг хамгаалах үйл ажиллагаанд хамтарч ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

4. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний Хөтөлбөр төслийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



ЭЭНХБАТ

626010653